



## "АДУУНЧУЛУУН" ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 06 сарын 04 өдөр

Дугаар 24/09

Чойбалсан хот

### Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 69 дугаар зүйл, Санхүүгийн Зохицуулах Хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоолоор батлагдсан "Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам" 2.2, 2.3, "Адуунчулуун" ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. "Адуунчулуун" ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2024 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн 10:00 цагт Дорнод аймаг, Хэрлэн сум, 8-р баг, "Адуунчулуун" ХК-ийн хурлын танхимд хуралдуулж дараах асуудлыг хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсүгэй. Үүнд:

- A. Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай
- B. Компанийн ногдол ашгийн талаар гаргасан Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг танилцуулах
- C. ТУЗ-ийн 2023 оны үйл ажиллагааны тайланг танилцуулах
- D. ТУЗ-ийн 2024 оны зардлын төсвийг батлах
- E. ТУЗ-ийн гишүүдийг сонгох /СЗХорооны 2020 оны 880-р тогтоолоор баталсан Санал хураах кумулятив аргаар/.

Хоёр. Хурал хуралдуулах тухай Хувьцаа эзэмшигчдэд үйлчилж буй брокер, дилерийн компаниудад мэдэгдэх хугацааг 2024 оны 06 дугаар сарын 14-ны өдрөөр, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн хугацааг 2024 оны 06 дугаар сарын 28-ны өдрөөр тогтоосугай.

"Адуунчулуун" ХК, өөрийн байр, 8-р баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, Монгол улс  
Утас/факс: 50021392, Имэйл: info@aduunchuluun.mn, Вэб: www.aduunchuluun.mn

Гурав. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцэн шийдвэрлэх асуудлыг саналын хуудсаар авах бөгөөд саналын хуудасны агуулга, загварыг 01 дүгээр хавсралтаар баталсугай.

Дөрөв. Хувьцаа эзэмшигчээс "Санал авах хуудас"-ыг хүлээн авах сүүлийн өдрийг харьяалагдах үнэт цаасны компаниар нь дамжуулан хурал хуралдах өдөр буюу 2024 оны 07 дугаар сарын 24-ны өдрийн 10<sup>00</sup> цагийн дотор, мөн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд оролцсон хувьцаа эзэмшигчээс санал хүлээн авахаар тогтсугай.

Тав. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын зарыг энэхүү тогтоолын 02 дугаар хавсралтаар баталж Монголын хөрөнгийн биржийн цахим хуудас, компанийн өөрийн цахим хуудас, өдөр тутмын сонинд 2024 оны 06 дугаар сарын 09-ний өдөр тутмын /Өдрийн сонин/ болон орон нутгийн телевиз /Мижиг телевиз, Жаран телевиз/-д тус тус мэдээлж, биелэлтэд нь хяналт тавьж ажиллахыг зохион байгуулах комисст даалгасугай.

Зургаа. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг хуралдуулахтай холбогдуулан хурлын дэгийг 03 дугаар хавсралтаар, хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчид нь энэхүү шийдвэрийн 04 дүгээр хавсралтад заасан бичиг баримттай 2024 оны 06 дугаар сарын 14-ны өдрөөс 2024 оны 07 дугаар сарын 24-ны өдөр хүртэл 08<sup>00</sup>-17<sup>00</sup> цагийн хооронд "Адуунчулуун" ХК-ийн байранд ирж танилцах, и-мэйлээр авах эсвэл харьяалагдах Үнэт цаасны компаниас авч танилцах эрхтэй болохыг дурдсугай.

Долоо. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын даргаар Цогтсайхан овогтой Шижир /ТУЗ-ийн дарга/-ийг томилж, тооллогын комисс болон зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнийг 05 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

Найм. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зохион байгуулах ажлын төлөвлөгөөг 06 дугаар хавсралтаар баталсугай.

Ес. "Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх тухай" журмын дагуу хурлын зарыг хүргэж, хурлыг бэлтгэл сайтай явуулахыг хурал зохион байгуулах комисс, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга А.Оюун-Эрдэнэ нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ШИЖИР